



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар A/97

Хажуу шинэ ус


Г Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.4, 48.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.3 дахь хэсэг, 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Сумын дэд станцын трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх” ажил 35,500,000.00 (Гучин таван сая таван зуун мянга) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Смарт контрол” ХХК шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. Сумын дэд станцын трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх” ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг “Смарт контрол” ХХК-д даалгасугай.

3. “Смарт контрол” ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) 4 дүгээр багийн Засаг дарга (Л.Батбаатар) нарт үүрэг болгосугай.



482401091